



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/690

Булган сум

**Булган аймаг дахь Хүний эрхийн төлөв байдлыг
тайлагнах орон тооны бус ажлын хэсгийг
байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дугаар тогтоолын хавсралтын 1.1.4.8, Хүний эрхийг хангах үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг дахь Хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах орон тооны бус ажлын хэсгийг 1 дүгээр, ажлын хэсэгт ирүүлэх мэдээллийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Нутаг дэвсгэрийн хэмжээнд Хүний эрхийг хангах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулан энэ чиглэлээр тусгай чиг үүрэгтэй албадад чиглэл өгч хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 17-ний өдрийн 1780 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ТАЙЛАГНАХ
ОРОН ТООНЫ БУС АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга
Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор
/Зөвшилцсөнөөр/
Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга
/Зөвшилцсөнөөр/
Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга
Байгаль орчны газрын дарга
Онцгой байдлын газрын дарга
Цагдаагийн газрын дарга
Мал эмнэлгийн газрын дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Сумдын Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга: Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

10 дугаар сарын 17-ний өдрийн А/ЗСЗ дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



АЖЛЫН ХЭСЭГТ ИРҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Хариуцах байгууллага	Ирүүлэх мэдээлэл	Хугацаа	Мэдээлэл ирүүлэх байгууллага
1	2	3	4	5
	Хууль,эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Тухайн орон нутгийн эмзэг бүлгийн иргэдийн талаарх тоо, мэдээ баримт судалгааг шинэчлэн гаргах/ хүүхэд, өсвөр үеийнхэн, хөдөөгийн ядуу иргэд, үндэстний цөөнх, ажилгүй, ур чадваргүй залуус, охид эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн эрчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, хот, суурин газрын ядуу иргэд, дотоодын шилжин суурьшигчид, бэлгийн цөөнх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, хүний эрхийг хамгаалагчид/	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, Цагдаагийн газар, сумдын Засаг даргын Тамгын газар
		Жендэр, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл зэрэгт суурилсан ялгаварлан гадуурхалтын талаарх тоо, мэдээ, баримт, судалгааг нэгтгэн гаргах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, Цагдаагийн газар, Нийт сумдын Засаг даргын Тамгын газар
		Уур амьсгалын өөрчлөлтөд өртөж байгаа хүрээлэн буй орчны тухай тоо, мэдээ бэлдэх, үйл явцыг баримтжуулан, судалж, үнэлэх	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Байгаль орчин аялал, жуулчлалын газар
		Ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, хэрэглээ, эрэлтийг судлах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар
		Орон нутаг дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх сэдэвчилсэн судалгаа хийж, дүн шинжилгээний үндсэн дээр түүнд суурилсан бодлого, төлөвлөлтийг боловсруулах, үр дүнг тооцож ажиллах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Орон тооны бус ажлын хэсэг

Хууль,эрх зүйн хэлтэс Нийгмийн бодлогын хэлтэс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн үр дүнг хүний эрхийн орон нутаг дахь төлөв байдлын 2024 оны тайлангийн хавсралтад тусгах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газар
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журамд заасан 10 шалгуур үзүүлэлтийн 5 ба түүнээс олон шалгуур үзүүлэлтүүдэд хангалтгүй оноо авч 10-аас хойш байрт эрэмбэлэгдсэн аймаг орон нутаг дахь мэргэжилтэн, оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж, авах арга хэмжээг боловсруулах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Орон тооны бус ажлын хэсэг
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Хүний хүчин зүйл болон байгалийн аливаа үзэгдлээс бий болж буй агаар, ус, хөрс, орчны бохирдол, барилга байгууламж, авто зам, хот суурин газрын аюулгүй байдал, стандарт, химийн хорт болон аюултай хог хаягдлын менежментийн асуудлыг нарийн зохицуулж үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Агаар, хөрс болон усны бохирдол, уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа орон нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдалт хяналт шалгалт хийх	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Булган аймгийн төвийн нийт цэгийн хяналт шинжилгээгээр хром, стронцийн дундаж агууламж стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн эсэхэд хяналт тавьж, бууруулах арга хэмжээ авах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Монгол Улсад Бүгд найрамдах Чех Улсаас хэрэгжүүлж буй "Хөгжлийн тусламжийн хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийн хүрээнд тус улсын санхүүжилтээр хийгдсэн Экологийн бохирдлыг арилгахад ноу-хау технологи нэвтрүүлэх 2-р шат Монгол Улс- Булган орчмын эрсдэлийн шинжилгээгээр "Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын газар болон ойр орчмын газрын хөрс маш их хэмжээгээр пестицидээр бохирдсон" гэх дүгнэлт гарсан тул	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мал эмнэлгийн газар

		мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилга газар болон ойр орчмын пестицидээр бохирдсон газрыг хуулах, цэвэрлэх, үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг яаралтай шийдвэрлэх		
	Нийгмийн бодлогын хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш хамруулах боломж нөхцөлийг бүрдүүлж, барилга байгууламж, зам талбайг "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага MNS 5682:2006", "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009" стандартад тус тус нийцүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байх, цаашид энэхүү стандартад нийцээгүй барилга байгууламж, зам талбайг хүлээн авахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, Газрын харилцаа хот байгуулалтын газар
		Ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийг ажилтай орлоготой болгох талаар ажил арга хэмжээ зохион байгуулсан тайлан	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар
	Нийгмийн бодлогын хэлтэс,	Эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 16 суманд хийж, 3899 иргэнийг хамруулж эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулж, хамрагдвал зохих 59553 иргэдээс 9147 буюу 15,4 хувийг хамруулаад байгаа ч аймгийн хэмжээнд өвчлөлийг бууруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, иргэдийн сэтгэл ханамжийг сайжруулахад анхаарах шаардлага байна.	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг
	Хууль, эрх зүйн хэлтэс	Төрийн алба хаагчдын гэмт хэрэг, зөрчил үйлдсэн талаарх мэдээлэл	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Аймгийн Прокурорын газар

		Төрийн албан хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, хандлага, туршлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
		Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн шүүхэд хандсан иргэдийн тоон мэдээлэл	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Аймгийн Шүүх
	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Орон нутгийн оршин суугчдын дунд хүнсний зориулалтын бус хуванцар савыг тэр дундаа ахуйн түвшинд хэдий хугацаанд ямар зориулалтаар ашиглаж байгааг баримтжуулах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Орон тооны бус ажлын хэсэг
	Хөрөнгө оруулалтын хэлтэс	Орон нутаг дахь Хүний эрхийн төлөв байдлын тайлан, илтгэлд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг хүний эрхийн орон нутаг дахь төлөв байдлын тайлангийн хавсралтад тусгах	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Орон тооны бус ажлын хэсэг
	Хууль, эрх зүйн хэлтэс Хууль, эрх зүйн хэлтэс Нийгмийн бодлогын хэлтэс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс Төрийн захиргаа удирдлагын хэлтэс	Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журмын боловсруулалтыг сайжруулах, тайланг тус журамд заасан бүтэц, шаардлагыг дагуу бэлтгэж, журамд заасан хугацаанд шуудангаар болон цахим /word болон pdf/ хэлбэрээр хүргүүлэх	Жил бүрийн 06 дугаар сарын 5, 12 дугаар сарын 01-ний дотор	Орон тооны бус ажлын хэсэг